1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	609,700.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,323,017,257.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,563,309,383.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,507,156,810.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>14,838,557.84</b>
210101	Үндсэн цалин	10,911,171.84
210102	Нэмэгдэл	1,707,386.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,220,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,847,663.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,256,413.00
210202	Тэтгэмжийн даатгал	147,812.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	118,249.00
210204	Ажилгүйдлийн даатгал	29,562.00
210205	Эрүүл мэндийн даатгал	295,627.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,576,100.00</b>

**Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,576,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36,680,423.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,850,000.00
210602	Тавилга	7,500,000.00
210604	Урсгал засвар	22,330,423.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>22,139,950.00</b>
210702	Дотоод албан томилолт	22,139,950.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,430,074,116.82</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,414,462,891.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,611,225.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,950,000.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,950,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,950,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>25,202,573.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	25,202,573.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>759,707,874.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	759,707,874.00
223001	Бусад хөрөнгө	759,707,874.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,323,017,257.66</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,323,017,257.66</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,455,024,253.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	525,134,139.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	342,858,864.26
131106	Төсвийн урамшуулал	
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Төр иргэн хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд ил тод байдлыг ханган хүн амын эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж байгалийн тэнцвэрт байдлыг хангана” гэж тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 онд шинэчлэн байгууллагын даргын тушаалаар батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,136,047.0 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

**Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Үзүүлэлт	Эхний үндэглэл	Эцсийн үндэглэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	495,526.8	728,085.5	232,558.7
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	239,097.3	267,907.4	28,810.1
Бараа материал	256,429.5	460,178.1	203,748.6
Үндсэн хөрөнгө	14,376,290.2	13,007,684.5	-1,368,605.7
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>14,871,817.0</b>	<b>13,735,770.0</b>	<b>-1,136,047.0</b>
Нийт өр төлбөр	209,463.7	0	-209,463.7
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,662,353.3	13,735,770.0	-926,583.3
Засгийн газрын хувь оролцоо	14,662,353.3	13,735,770.0	-926,583.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,871,817.0	13,735,770.0	-1,136,047.0

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 28,810.1 мянган төгрөгөөр өссөн нь баяр наадмын зардал болон албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон зарцуулалтын үр дүнд бий болсон авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 460,178.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 203,748.60 мянган төгрөгөөр өссөн нь баяр наадмын зардлыг худалдан авалтын хүрээнд бий болсон аж ахуйн материал, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Сүм хөх бүрдийн барилга байгууламжид хийгдэх засварын ажлын барилгын материалын бүртгэлтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгө болон хандив тусламж бусад эх үүсвэрээр ирсэн 2,213,729.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж, 3,104,983.9 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, 507,392.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,735,770.00 мянган төгрөг болж өмнөх оноос 926,583.30 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,775,740.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 7,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,782,740.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 72,884.2 мянган төгрөгөөр бууруулж, 2,702,855.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 он төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан боловч харьяа дээд газраас тогтмол зардлууд болон урсгал зардлуудыг өмнөх

оны төсвийн дүнгээр болгож, харин цалингийн зардлыг нэмэгдлийн зөрүүгээр нэмэгдүүлж өгсөн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,702,855.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 7,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилт болох 2,702,855.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 7,609.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 108.5 хувиар давуулан биелүүлсэн боловч төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдүүлсэн 7,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,646,213.9 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 30,685.8 мянга, нийтлэг үйлчилгээний зардлыг 10,924.3 мянга, Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлыг 10,862.0 мянган төгрөгөөр, орон нутгийн нөөц хөрөнгийг 11,169.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Төсвийн хэмнэлт 57,251.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106 - Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2,709,855.8	2,646,213.9	63,642.0	97.7
2	80101 – Үндсэн үйл ажиллагааны зардал	1,102,808.7	1,072,122.9	30,685.8	97.2
3	80112 - Нийтлэг үйлчилгээ	466,034.9	455,110.6	10,924.3	97.7
4	80802 – Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	141,553.0	130,691.0	10,862.0	92.3
3	80813 - Хуульд заасан үндэслэлээр албан хаагчдад олгох нөхөн олговор	8,517.1	8,517.1	-	100
5	81102 – Орон нутгийн нөөц хөрөнгө	958,805.3	947,635.5	11,169.8	98.8
6	80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	16,511.8	16,511.8	-	100
7	80714 – Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	10,000.0	10,000.0	-	100
8	80801 – Нөхөн олговор	5,625.0	5,625.0	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 525,134.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 342,858.9 мянга, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 1,455,024.3 мянга нийт 2,323,017.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Нэмэлт төсвийг цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 14,838.6 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,847.7 мянга, хангамж, бараа материалын зардалд 1,576.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 36,680.4 мянга, дотоод албан томилолтын зардалд 22,139.9 мянга, бараа үйлчилгээний зардал 1,430,074.1 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 30,950.0 мянга, бусад үндсэн хөрөнгийн зардалд 759,707.9 мянга төгрөг буюу нийт 2,297,814.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үлдэгдэл 25,202.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Өмнөх оноос нэмэлт төсвийн орлого 1,403,155.3 мянга, зардал 1,698,264.5 мянган төгрөгөөр өссөн тайлант онд Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн баяр наадмын үйл ажиллагааны зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсангай холбоотой байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Ихбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын захирал, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 02/139 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.



Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт хөрөнгийн дүн 13,735,770.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 137,357.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад 30 арга хэмжээг түүвэрлэн авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.7 дахь заалтуудыг зөрчин 2,566.2 мянган төгрөгийг зарцуулсан зөрчлийг илрүүлж төлбөрийн акт тогтоосон.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 онд нийт 12,579,007.9 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 3,028,384.1 мянган төгрөгийн 131 мэдээллийг байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзэн зөвлөмж өгсөн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн, хариуг Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт

**Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	978.0	1	978.0	100
Албан шаардлага	3	45,052.5	3	45,052.5	100
Зөвлөмж	1	-	1	-	
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>46,030.5</b>	<b>4</b>	<b>46,030.5</b>	

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хийх, тээвэр шатахууны зарцуулалтад давтан тооцоолол хийх горим сорилыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,800.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон.

*Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулсан.*

Аудитаар нийт 103,105.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илрүүлэн 2,566.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 88,389.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, 12,150.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс **887,131.00** /Найман зуун наян долоон мянга нэг зуун гучин нэгэн/ төгрөгийн балансын урамшуулал олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2.-т /Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно./, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Байгууллагын төсвөөс **1,679,100.00** /Нэг сая зургаан зуун далан есөн мянга нэг зуун/ төгрөгөөр согтууруулах ундаа худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.7. /байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно./, тухайн үед мөрдөгдөж байсан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.9-д /Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно/ заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.*

## 5.2 Албан шаардлага

1. Аудитаар аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулаагүй, баяр наадмын зардалд тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн 70,000,000.00 /далан сая/ төгрөг зарцуулсан.

Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, мөн хуулийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулахад нь хяналт тавих/, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 –д /17.1.4.аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан зарцуулах/, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын 1 –д /Үндэсний их баяр наадмын арга хэмжээн д зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай/ заасныг тус тус зөрчсөн.

2. Засгийн газрын тогтоосон босго үнээс дээших үнийн дүн бүхий ойн баяр наадмын зардлын худалдан авалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.
3. Засаг даргын Тамгын газрын тээвэр шатахууны зардлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.-т /хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох/, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т /Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар/, 33 дугаар зүйлийн 33.1 –д /Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно/, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтын 2–т /Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд – 20.0 сая/ заасныг тус тус зөрчсөн.

4. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас төрийн албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.
5. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас ажилчдад биеийн тамирын хувцас худалдан авч өгсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/, Сангийн сайдан 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврын "Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал" зардлын тайлбарт "Ажиллагчдын цалин хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) бодогдох нэмэгдэл урамилын зардлууд энэ ангилалд хамаарна.", "Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал" зардлын тайлбарт "Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчид голдуу хагас бүтэн жилийн эцэст нэг удаа олгох мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна" заасныг тус тус зөрчсөн.

6. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөт орлого 7,000,000.00 төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулж, байгууллагын орлогын төлөвлөгөөний биелэлтийг зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т /үнэн зөв байх;/, 14 дүгээр зүйлийн 14.4.5.-д /бүх орлого/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.1.-д /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх:/, 44 дүгээр зүйлийн 44.3. –т /Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно./ заасныг тус тус зөрчсөн.

*Шийдвэрлэсэн: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.*

### 5.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:* Баяр наадмын үйл ажиллагааны хүрээнд бий болсон тус бүр нь 450.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 5 ханатай гэрийн халзтай 27 ширхэг шар бүрээсийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 15 сумын ЗДТГ-г тарааж бүртгэл тайланд тусгаагүй.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг ямар үнэ өртгөөр бүртгэлд тусгах талаар сумдад нэгдсэн чиглэл өгч биелэлтийг нь хангуулж ажиллах.

*Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.*

1.2. *Илрүүлэлт:* Бэлнээр болон бэлэн бусаар худалдан авсан бараа бүтээгдэхүүний төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр худалдан авч буй ажил үйлчилгээний төлбөр тооцоог хийхдээ хууль тогтоомжид заасан анхан шатны баримтын бүрдэл хангагдсан эсэх хяналт тавьж нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримталж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 09 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. *Илрүүлэлт:* Шилэн дансны хугацаа хоцролтын хэрэгжилт 100 хувьтай боловч мэдээлсэн байдлын хэрэгжилт 80.1 хувьтай байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон.	1	2,800.0			1	2,800.0	1	2,800.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,800.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2,800.0</b>	<b>1</b>	<b>2,800.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөт орлого 7,000,000.00 төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулж, байгууллагын орлогын төлөвлөгөөний биелэлтийг зөрүүтэй тайлагнасан.	1	7,000.0			1	7,000.0						
Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баглуулаагүй, баяр наадмын зардалд тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн 70,000,000.00 /далан сая/ төгрөг зарцуулсан.	1	70,000.0			1	70,000.0						
Баяр наадмын үйл ажиллагааны хүрээнд бий болсон тус бүр нь 450.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 5 ханатай гэрийн халзтай 27 ширхэг шар бүрээсийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 15 сумын ЗДТГ-г тарааж бүртгэл тайланд тусгаагүй.	1	12,150.0					1	12,150.0				
Нэмэлт санхүүжилтийн төсвөөр согтууруулах ундаа худалдан авсан.	1	1,679.1	1	1,679.1								

**Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас төрийн албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.	1	562.5			1	562.5						
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас ажилчдад биеийн тамирын хувцас худалдан авсан.	1	10,826.5			1	10,826.5						
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>102,218.1</b>	<b>1</b>	<b>1,679.1</b>	<b>4</b>	<b>88,389.0</b>	<b>1</b>	<b>12,150.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Тус байгууллагын 2022 оны шилэн дансны мэдээллийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,296.6 сая төгрөгийн зарлагын 73 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 1,731.8 сая төгрөгийн 58 шийдвэрийг мэдээлээгүй байна. Мөн цахим хуудаст мэдээлсэн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн хуулбарыг огт байршуулаагүй.	1						1					
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												

**Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Засгийн газрын тогтоосон босго үнээс дээших үнийн дүн бүхий ойн баяр наадмын зардлын худалдан авалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.	1				1							
Засаг даргын Тамгын газрын тээвэр шатахууны зардлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.	1				1							
Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс балансын урамшуулал олгосон.	1	887.1	1	887.1								
Бэлнээр болон бэлэн бусаар худалдан авсан бараа бүтээгдэхүүний төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн.	1						1					
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>887.1</b>	<b>1</b>	<b>887.1</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>887.1</b>	<b>1</b>	<b>887.1</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>